210406	Бага үнэтэй, турган элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	127,800.00	127,800.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,328,200.00	15,860,450.00	15,860,450.00	-2,910,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,568,200.00	4,475,900.00	4,475,900.00	0.00
210604	Урсгал засвар	11,410,000.00	11,384,550.00	11,384,550.00	-2,910,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,735,300.00	3,492,000.00	3,492,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	3,735,300.00	3,492,000.00	3,492,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	36,871,000.00	28,963,882.00	28,963,882.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,140,000.00	21,647,306.00	21,647,306.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	664,000.00	423,335.00	423,335.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	114,000.00	77,000.00	77,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн	6,870,000.00	6,750,000.00	6,750,000.00	0.00
210807	Газрын төлбөр	1,083,000.00	66,241.00	66,241.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,476,500.00	73,439,710.00	35,119,110.00	38,320,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад	102,836,200.00	67,265,210.00	67,265,210.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,640,300.00	6,174,500.00	6,174,500.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,851,100.00	19,725,375.00	19,725,375.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,851,100.00	19,725,375.00	19,725,375.00	0.00

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,932,800.00	18,932,800.00	18,932,800.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	792,575.00	792,575.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	495,734,500.00	210,445,875.00	25,500,000.00	184,945,875.00
223001	Бусад хөрөнгө	495,734,500.00	210,445,875.00	210,445,875.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР	150,000,000.00	150,836,777.00	150,836,777.00	-1,800,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	150,000,000.00	150,836,777.00	150,836,777.00	-1,800,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,613,167,800.00	1,298,064,883.73	1,086,195,761.50	50,230,622.23
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	707,155,849.00	-707,155,849.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	745,653,049.00	-745,653,049.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	844,804,200.00	1,051,358,707.73	0	891,520,207.73
320001	Орон нутгийн төсвөөс	718,069,700.00	924,624,059.73	0	764,785,559.73
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	126,734,500.00	126,734,648.00	126,734,648.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	768,363,600.00	246,706,176.00	379,039,912.50	-134,133,736.50
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	231,303,700.00	177,714,126.00	114,991,726.00	60,922,400.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,131,600.00	68,992,050.00	68,992,050.00	0.00
350003	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	492,928,300.00	0	398,587,512.50	-398,587,512.50
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	147,163,209.55	0	147,163,209.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	144,470,328.14	0	144,469,357.50

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,094,460.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,094,460.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,120,740.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,850,000.00
210604	Урсгал засвар	1,850,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,270,740.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,270,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,973,720.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,973,720.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,973,720.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,094,460.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,094,460.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,094,460.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.39

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сумын санхүүгийн алба нь Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил гүйлгээг хянах, ажил гүйлгээг батлах чиг үүргийг гүйцэтгэдэг.

Санхүүгийн албанд дарга-1, мэргэжилтэн-1, нягтлан бодогч -3 нийт 5 орон тоотой ажиллаж байна. Тус суманд төсөвт байгууллага-6, орон нутгийн сан-3 үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1. "Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2. Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3. Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөж хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрд сумын Төрийн сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.394.3 сая төгрөгөөр буурсан байна.

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	586.9	535.5	-51.4
Авлага	258.4	393.8	135.3
Бараа материал	241.8	28.5	-213.5
Үндсэн хөрөнгө	8,072.3	1,807.4	-6,264.9
Нийт хөрөнгө	9,159.5	2,765.2	-6,394.3
Өр төлбөр	77.5	93.7	16.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,082.0	2,671.5	-6,410.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,159.5	2,765.2	-6,394.3

Тайлант онд сумын ОНХСанд 174.4 сая төгрөг, СХСанд 38.8 сая төгрөгийн авлага нэмэгдэж, Улсын төсвийн байгууллагуудын /ЕБС, СТөв, СӨБ, ЭМТ/ авлага 77.8 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл 213.5 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 6,264.9 сая төгрөгөөр буурсан нь мөн боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр 16.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ОНХСанд 92.7 сая төгрөгийн өглөг нэмж бүртгэсэн, ЭМТөвийн 75.9 сая төгрөгийн өмнөх оны өглөг хасагдсантай холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 535.5 сая төгрөг болж, өмнөх оноос 51.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0	0	
Банканд байгаа бэлэн мөнгө	586.9	535.5	-51.4
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	586.9	535.5	-51.4
Арилжааны банк дахь харилцах			
Дүн	586.9	535.5	-51.4

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэлтэй байна. СХСан, ЭХСан ОНӨОрлого, ОНХСан зэрэг байгууллагууд мөнгөн хөрөнгийг үлдэгдэлтэй гарчээ. Мөн Сургууль, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн орон нутгийн төсвийн дансанд 1.5 сая төгрөгийн үлдэгдэл байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 393.8 сая төгрөг болж, өмнөх оноос 135.3 сая төгрөгөөр өссөн байна.

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	1.0		-1.0
Татаас санхүүжилтийн авлага	75.8		-75.8
Зээлийн хүүгийн авлага	4.6	5.3	0.7
Татвар шимтгэлийн авлага	0.9		-0.9
Байгууллагаас авах авлага	0.1	0	-0.1
Хувь хүмүүсээс авах авлага	175.9	388.4	212.5
Дүн	258.4	393.8	135.3

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын 98.6 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. СХСангаас олгосон зээлийн авлага 214.0 сая төгрөг, ОНХСангийн авлага 174.4 сая төгрөг тус тус байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 28.5 сая төгрөг болж, өмнөх оноос 213.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	60.6	0	-60.6
Тусгай зориулалттай материал	12.7	0	-12.7
Эм боох материал	47.9	0	-47.9
Дуусаагүй үйлдвэрлэл			
Бэлэн бүтээгдэхүүн		28.5	-152.7
Хангамжийн материал	181.2	0.5	-4.1
Бичиг хэргийн материал	4.6	28.0	-116.8
Аж ахуйн материал	144.8		
Сэлбэг хэрэгсэл			
Түлш, шатах тослох материал			
Барилгын засварыг материал		0	-31.4
Хүнсний материал	31.4	0	-0.4
Бусад хангамжийн материал	0.4		
Мал амьтад	241.8	28.5	-213.5

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 213.5 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын бараа материалын эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,807.4 сая төгрөг болж, өмнөх оноос 6,264.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	8,002.1	1,772.4	-6,229.7
Барилга, байгууламж, орон сууц	6,832.6	876.0	
Авто-тээврийн хэрэгсэл	141.4	215.4	
Машин тоног төхөөрөмж(компьютер)	643.0	434.4	
Тавилга, аж ахуйн эд хогшил	117.1	32.1	
Бусад үндсэн хөрөнгө	264.9	214	
Ном	3.1	0.4	
Биет бус хөрөнгө	70.2	34.9	-35.2
Программ хангамж	0.5	0.3	
Бусад биет бус хөрөнгө	69.7	34.7	

ӨВА-2023/02/НА-СТА-ТТЗ

16

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дүн	8,072.3	1,807.4	-6,264.9
-----	---------	---------	----------

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 6,264.9 сая төгрөгөөр буурсан нь боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэнтэй холбоотой.

Сумын ЗДТГ, ИТХ зэрэг байгууллагууд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 386.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэлд авсан, 35.9 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө худалдан авч бүртгэлд тусгажээ.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 93.7 төгрөг болж, өмнөх оноос 16.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	60.7		-60.7
Бараа үйлчилгээний зардлын өглөг	5.6	0	-5.6
Байгууллагад төлөх өглөг	11.2	93.7	82.5
Хувь хүмүүст төлөх өглөг			
Дүн	77.5	93.7	16.2

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ЭМТөвийн өмнөх оны өглөг 75.9 сая төгрөгөөр буурч, ОНХСанд 92.7 сая төгрөгийн өглөг шинээр бүртгэгдсэн байна

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,671.5 сая төгрөг болж, өмнөх оноос 6,410.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,265.5	891.2	-1,374.3
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,265.5	891.2	-1,374.3
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн	2,418.9	1,251.7	-1,167.2
Өмнөх үеийн үр дүн	2,030.7	7,685.0	5,654.4
Тайлант үеийн үр дүн	388.3	-6,433.3	-6,821.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,397.6	528.6	-3,869.0
Дүн	9,082.0	2,671.5	-6,410.5

Эх сурвалж: ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмчийн дүн буурсан нь улсын төсвийн байгууллагуудын хөрөнгийн эхний үлдэгдлийг зардалд хааснаас тайлант оны үр дүн буурсантай холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2021 оны 5/04 тоот тогтоолоор 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,678.8 сая төгрөгөөр баталжээ.

ӨВА-2023/02/НА-СТА-ТТЗ

17

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 9/08 тогтоолоор төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,613.1 сая төгрөг болгон бууруулж баталсан байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 69.1 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой.

Сумын төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 204.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 375.6 сая төгрөг буюу 84.1 хувиар давж биелжээ.

Хүснэгт-9

сая төгрөгөөр

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	31,259	49,163	17,904	157.3
2	Сүүтэн / цалин хөлс түүнтэй	91,294	119,000	27,706	130.3
3	ХХОАТ-ын буцаан олголт		(16,096)	(16,096)	
4	Хөрөнгийн орлого /хадгаламж хүү/	47,892	37,617	(10,276)	78.5
5	Хөрөнгө борлуулсны орлого			-	#DIV/0!
6	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны	1,656	7,067	5,411	426.8
7	Бууны албан татвар	2,220	1,290	(930)	58.1
8	Улсын тэмдэгтийн хураамж	2,000	806	(1,194)	40.3
9	Түгээмэл тархалтай АМНАТ	200		(200)	0.0
10	Хог хаягдлын хураамж	4,400	3,870	(531)	87.9
11	Газрын төлбөр	2,829	1,210	(1,619)	42.8
12	Ангийн орлого		154,320	154,320	
13	Ус ашигласны төлбөр			-	
	Татварын орлого	183,751	358,246	174,495	195.0
1	Татварын бус/ Хүү, торгуулийн орлого	20,282	17,324	(2,959)	85.4
	Бусад орлого			-	
	Нийт дүн орлого	204,032.6	375,569.5	171,536.9	184.1

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн ч бууны албан татвар, газрын төлбөр, хадгаламжийн хүүгийн орлого, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын хураамж зэрэг татварууд 12.1-60.0 хувиар тасарсан байна. Мөн АМНАТ-ийн орлогын гүйцэтгэл 0 байна.

ХХОАТ, үйл ажиллагааны орлого, ан амьтны нөөц ашигласны төлбөр 30-100 хувь давсан байна. Ангийн орлогын төлөвлөгөө батлаагүй байсан учраас орлогын төлөвлөгөөний биелэлт өндөр хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 50.1 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл хөтөлбөр байхгүй байна.

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын захирал, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрд сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 01/64 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 1,158.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор суманд олгох санхүүгийн дэмжлэг буурч, төсөвтөө хасах тодотгол хийсэн ба тэр хэмжээгээр холбогдох зардлууд хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бүрд сумын ТТЗ нь 2022 онд 155 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 154 мэдээллийг ил тод мэдээлсэн, 1 мэдээллийн хугацаа болоогүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тус байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар ТТЗ-тай холбоотой зөрчил илрээгүй.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 20.1 сая төгрөгийн алдаа¹ илэрч аудитын явцад залруулсан.

Цэцэрлэгийн орон нутгийн өмчөөс төрийн өмчид үндсэн хөрөнгө бараа материалыг шилжүүлэх хаалтын бичилтийг 20.1 сая төгрөгөөр зөрүүтэй бичилт хийсэн энэхүү залруулга нь нийт буруу илэрхийллийн дүнд орохгүй.

Аудитаар 11.1 сая төгрөгийн 2 зөрчил² илэрч, 11.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

2021 оны агнуурын нөөц ашигласны давсан орлогоос 2022 онд 60.5 сая төгрөгийг Байгаль хамгаалах санд хуваарилснаас 11.1 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Шийдвэрлэлт:

Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шийдвэр гаргалт, үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сумдын төсөвт байгууллагуудын дарга нарт үр чадварын нэмэгдэл олгохдоо ажлын үр дүнтэй уялдуулж хувь хэмжээг тогтоож, тухай бүр шийдвэр гаргаагүй, бүтэн жилээр тогтмол олгож ирсэн байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлагуудын үр чадварын нэмэгдлийг улирал тутам ажлын үр дүнгийн үзүүлэлттэй уялдуулан тухай бүр тогтоож олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 4 байгууллагын 3-г түүвэрт хамруулсан./ ИТХ, ОНХСан, СХСан/ Сумын ЗДТГ "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан байна.

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 6.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 6.9 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлжээ.

• ИТХ-д 6.6 сая төгрөгийн дараах алдаа, зөрчлүүд илэрсэн.

- Тээвэр шатахууны зардлыг зарцуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж зарцуулсан

- Аймгийн ИТХТ-ийн 2021 оны 30 дугаар тогтоолоор "Амар тайван Өвөрхангай" хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд тус сумын ИТХ-аас "Архигүй орчин-Архидан соотуурахын эсрэг хамтдаа" сарын аян зохион байгуулж, ГХУС-х арга хэмжээний зардлаас 2,100.0 мянган төгрөгийг "Дэжээ", "Гар бөмбөг" тэмцээний шаангалын санд зарцуулсан

- ТХ-ын нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 22 өдрийн тушаалаар Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 640.0 мянган төгрөгийн тэмдэглэлийн дэвтэр, бал худалдан авсан

- Бараа үйлчилгээний бусад зардлаас МУ-ын начин С.Мандахад 500.0 мянган төгрөгийн дэмжлэг, Алдарт эхийн одон гардуулах үйл ажиллагаанд 957.0 мянган төгрөгийн өргөмжлөл өгч нийт 1,457.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн

• Сумын ОНХСан дараах зөрчил илэрсэн.

- Шилэн дансны сайтад нийт 151 мэдээлэл оруулснаас 43 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчил илэрчээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
						Үүнээс		Залруулаагүй			
	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүрд ТТЗ	1	20.1		1	20.1	1	20.1				
Дүн											

Бүрд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/									
			Үүнээс									
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяриуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүрд ТТЗ	2	11.1			1	11.1	1	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Үүнээс					
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР